

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	11
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
2.12. Шилэн дансны мэдээлэл	13
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3. Менежментийн захидал	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
ОССК	Орон сууц санхүүжилтын корпораци
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Х.БАДЕЛХАН ТАНАА

2020.04.24 № 1328
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС -д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Х.Баделхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийг чөлөөлөх асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн шийдвэрлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-наас 2020 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор О.Баярмаа, гэрээт аудитор Ш.Гүрпүрэв нар хариуцаж гүйцэтгэв.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/1214 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

БХБЯ-ны эрхэм зорилго нь барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БХБЯ нь үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж, стратегийн зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Нийтийн аж ахуй, орон сууцны салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг бодлогын удирдамжаар хангах, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Тус яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан хууль тогтоомж болон бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

Тайлант онд Сангийн сайдын 2017 оны 357 дугаар тушаал, Сангийн яамны ТНБД-ын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10/6988 дугаар албан тоотоор ирүүлсэн чиглэл, Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулиар гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн төсвийг Сангийн сайдын төсвийн багцад оруулж баталсан зэргийг үндэслэн Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл, Тайшир-Алтай ус хангамжийн төсөл, Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн орон сууцны хорооллын дэд бүтэц төсөл, Эрдэнэт хотын бохир усны цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл хэрэгжүүлэх нэгж, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн “Өмнөговь, Дорноговь аймгуудын хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл” зэрэг төслүүдийн хаалтын санхүүгийн тайланг гаргаж, Сангийн яаманд шилжүүлсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт болон журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна.

Барилга, хот байгуулалтын яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

БХБЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2019 онд харьяа 3 байгууллагын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны зарим хэсэгт төлөвлөгөөний дагуу 3 удаа аудит хийж, нийт 1,600.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн 37 зөвлөмж өгснөөс, 2 байгууллага 17 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 байгууллагын 20 зөвлөмж хэрэгжих

шатандаа байна. Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр тусгайлан аудит хийхээр төлөвлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 239,845.8 сая төгрөгийн 1 хувь буюу 2,398.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 29,478.6 сая байснаас, эцсийн үлдэгдэл 28,065.7 сая төгрөг болж, 1,412.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	5.2	0.4	-4.8
Банкинд байгаа бэлэн мөнгө	29,473.4	28,065.3	-1,408.1
Дүн	29,478.6	28,065.7	-1,412.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	17,434.6	13,089.0	-4,345.6
Төсөл	382.2	162.4	-219.8
ТӨҮГ	11,661.8	14,814.3	3,152.5
Дүн	29,478.6	28,065.7	-1,412.9

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь ТОСК ТӨХХК нь зээл болон зээлийн хүүгийн төлбөрт 1,991.4 сая төгрөгийг төлсөн, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайдын багцад шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Мөн ТӨҮГ-ын мөнгөн хөрөнгө өссөн нь Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БХБЯ, ЭМЯ, БСШУСЯ-дын захиалгаар баригдаж байгаа барилга байгууламжид захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн, барилга байгууламжийн төсөвт өртгийн дүнгээс 0.18 хувиар тооцож төвлөрүүлэх норм, нормативын сангийн орлого болон барилгын материал, сорил шинжилгээний лабораторийн орлого өссөн зэргээс шалтгаалсан байна.

2.8.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 152,708.8 сая төгрөг болж, 10,444.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	5.3	12.2	6.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	13.5	931.5	918.1
Татаас, санхүүжилтийн авлага	15.3	10.0	-5.3
Дансны авлага /ТӨҮГ/	137,382.1	149,352.1	11,969.9
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	3,586.6	1,835.0	-1,751.6
Бусад авлага	1,262.0	568.0	-694.0
Дүн	142,264.7	152,708.8	10,444.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	34.0	956.5	-922.5
Төсөл	16.8	96.5	-79.7
ТӨҮГ	142,214.0	151,655.9	-9,441.9
Дүн	142,264.7	152,708.8	-10,444.1

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 117 дугаар тогтоолын дагуу “Шинэ яармаг төсөл”-ийг хэрэгжүүлэхээр Хөгжлийн банкнаас Юнайтад прожект групп ХХК-тай хөрөнгө оруулалтын дамжуулан зээлийн гэрээ байгуулан 50.0 сая ам.долларын, 8.45 хувийн хүүтэй зээлийг олгосон ба зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүйгээс зээл, зээлийн хүүгийн төлбөр, валютын ханшийн зөрүүгээс нийт 13,256.5 сая төгрөгийн авлага ТОСК ТӨХХК-д үүссэнээс шалтгаалжээ.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 13,245.3 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 15.4 сая төгрөг болж, 13,229.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13,245.3	15.4	-13,229.9
Дүн	13,245.3	15.4	-13,229.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	320.0	15.4	-304.6
Төсөл	12,925.3	-	-12,925.3
Дүн	13,245.3	15.4	-13,229.9

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал буурсан нь Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл /нэмэлт санхүүжилт/-ийн 1,055.2 сая төгрөгийн, Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн орон сууцны хорооллын дэд бүтэц төслийн 11,870.1 сая төгрөгийн урьдчилгааны үлдэгдэлтэй төслүүдийг Сангийн яаманд шилжүүлсэн, ГЗБГЗЗГ өмнөх оны техник хяналтын урьдчилгаа төлбөрийн тооцоог барагдуулсан зэрэгтэй холбоотой байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 14,284.1 сая төгрөг болж, 16,949.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	15.8	20.8	5.0
Дуусаагүй үйлдвэрлэл	30,442.6	13,263.8	-17,178.8
Бэлэн бүтээгдэхүүн	185.0	256.3	71.3
Бичиг хэргийн материал	104.6	133.6	29.0
Аж ахуйн материал	130.4	140.8	10.4
Түлш, шатах тослох материал	1.9	1.6	-0.3
Хүнсний материал	0.0	0.2	0.2
Бусад хангамжийн материал	341.1	453.5	112.4
Мал амьтад	12.5	13.5	1.0
Дүн	31,233.9	14,284.1	-16,949.8

<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	515.5	653.1	-137.7
Төсөл	19.0	31.6	-12.6
ТӨҮГ	30,699.4	13,599.4	17,100.0
Дүн	31,233.9	14,284.1	16,949.8

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл буурсан нь ТОСК ТӨХХК-ийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй, Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлсэн Улаанбаатар хотод байрлах 972 айлын орон сууц /Буянт-ухаа 2/, Говь-Алтай, Хөвсгөл, Орхон аймгуудад байрлах баригдаж дуусаагүй барилгуудыг Хөгжлийн банканд төлөх өрийн төлбөрт хураалгаснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ТОСК ТӨХХК нь бараа материалын бэлэн бүтээгдэхүүний дансанд 2.5 сая төгрөгийн хангамжийн материалыг ангилал буруу бүртгэсэн;

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 167,122.8 сая төгрөг болж, 267,016.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	<i>/сая төгрөг/</i>
			Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	5,571.6	79,740.6	74,169.0
Авто-тээврийн хэрэгсэл	1,879.5	2,142.6	263.1
Машин тоног төхөөрөмж	5,643.9	5,732.4	88.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	959.6	925.2	-34.4
Бусад үндсэн хөрөнгө	26.5	39.9	13.4
Дуусаагүй барилга, байгууламж	350,651.6	9,606.5	-341,045.1
Ном	1.2	1.2	0.0
Программ хангамж	500.1	490.5	-9.6
Бусад биет бус хөрөнгө	67,821.7	67,848.3	26.6
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,083.8	595.7	-488.1
Дүн	434,139.5	167,122.8	-267,016.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	233,158.1	13,608.0	-219,550.1
Төсөл	124,319.5	74,627.1	-49,692.4
ТӨҮГ	76,661.9	78,887.7	-2,225.8
Дүн	434,139.5	167,122.8	-267,016.7

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламжийг ашиглагч байгууллагад холбогдох шийдвэрийн дагуу шилжүүлсэн, мөн 3 төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайдын багцад шилжүүлсэнтэй холбоотой байна. Тухайлбал:

- ТӨБЗГ-ын 2019 оны 249 дүгээр тогтоолоор БХБЯ-ны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,138.8 сая төгрөгийн балансын үнэтэй, барилгын сорилт, шинжилгээний лабораторийн хөрөнгийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсэн,
- ТӨБЗГ-ын 2019 оны 328 дугаар тогтоолоор БХБЯ-ны захиалгаар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан, нийт 33,984.5 сая төгрөгийн үнэ бүхий дэд бүтцийн барилга байгууламжийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэн,
- ТӨБЗГ-ын 2019 оны 367 дугаар тогтоолоор Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 49,806.0 сая төгрөгийн хөрөнгийг Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д тус тус шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тус яаманд "Дэд бүтэц төсөл" хэрэгжиж дууссантай холбогдуулан төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан Hundai sonata-7 маркийн автомашиныг 2016 оны 12 сард балансаас балансад шилжүүлсэн боловч одоогоор албан хэрэгцээнд ашиглагдахгүй байна. Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон уг автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй;
- ТОСК ТӨХХК нь "Буянт Ухаа хорооллын ус дулаан дамжуулах төв 5"-ын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 263.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн, 3,020.2 сая төгрөгийн анхны өртөгтэй инженерийн шугам, хоолойн байгууламжийг хөрөнгөд бүртгээгүй;

2.8.6 Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 96,968.4 сая төгрөг болж, 21,632.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад өглөг	97,048.3	78,295.4	-18,752.9
Байгууллагад төлөх өглөг	96,462.1	76,930.2	-19,531.9
Хувь хүмүүст төлөх өглөг	76.4	0.2	-76.2
Татварын өглөг /ТӨҮГ/	47.1	272.4	225.3
Дансны өглөг /ТӨҮГ/	462.7	1,092.6	629.9
Урьдчилж орсон орлого	21,552.4	18,673.0	-2,879.4
Бусад урьдчилж орсон орлого	21,552.4	18,673.0	-2,879.4
Дүн	118,600.7	96,968.4	-21,632.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	13,538.5	13,100.7	-437.8
Төсөл	25,727.8	8.4	-25,719.4
ТӨҮГ	79,334.4	83,859.3	4,524.9
Дүн	118,600.7	96,968.4	-21,632.3

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл буурсан нь Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжлийн төсөл, Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн орон сууцны хорооллын дэд бүтэц төслийг Сангийн сайдын багцад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөн БХБЯ нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үе шатны ажлын гүйцэтгэл тус бүрээс барьцааг байршуулсантай холбоотой гүйцэтгэгч байгууллагуудад өгөх барьцаа хөрөнгө өссөн, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын өглөгийн дансанд бүртгэсэн барилга байгууламжийн норм, нормативийн сангийн орлого төвлөрүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой өглөг өссөн байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл буурсан нь ТОСК ТӨХХК-ийн Буянт-Ухаа-1, Буянт-Ухаа-2 хорооллын авто зогсоолыг олон жил хувааж төлөх нөхцөлөөр борлуулснаар худалдан авалт нэмэгдэж, орсон орлогыг урьдчилж орсон орлогод бүртгэснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Тус яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 134.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Тус яамны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд нийт 187 аж ахуйн нэгж байгууллагын 12,938.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 45 аж ахуйн нэгж байгууллагын 804.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, холбогдох баримтын бүрдэл дутуу, шалтгаан тодорхойгүй 22 аж ахуйн нэгж байгууллагын 890.2 сая төгрөгийг барьцаанаас чөлөөлөх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй;
- ТОСК ТӨХХК нь "Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК-аас шилжүүлэн бүртгэсэн харилцагчийн 167.2 сая төгрөгийн өглөгийн тодорхой бус үлдэгдэлтэй;
- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн 14 их засварын ажилд зохиогч байхгүй тул 12.0 сая төгрөгийг зарцуулаагүй, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

барьсан барилгын зураг төслийн баримт бичигт магадлал хийсэн нэр бүхий 12 эксперт нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өөр байгууллагад хянах эрх шилжүүлсэн 1.8 сая, нийт 13.8 сая төгрөгийн өглөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;

- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь нэр бүхий 6 аймагт 2012-2018 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн дагуу барьсан барилгуудад зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч компани болон орон нутгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан боловч захиалагчийн хүсэлтээр зарим барилгын үе шатны ажлыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аар техникийн хяналтыг хэрэгжүүлэн, олгосон санхүүжилтээс журмын дагуу зохиогчийн хяналтын зардлыг 20 хувиар тооцон, нийт 27.5 сая төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь хувийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэрээний дагуу хэрэгжүүлсэн 86.9 сая төгрөгийн 104 зураг төслийн магадлалын хяналтын ажлын холбогдох баримтын бүрдэл дутуу, гэрээг дүгнэж экспертийн цалин олгоогүй;
- Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь өглөгийн үлдэгдэл 8.3 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

2.8.7 Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 280,439.7 сая төгрөг болж, 6,590.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	103,822.0	175,946.8	72,124.8
Арилжааны банк	183,208.0	104,492.9	-78,715.1
Дүн	287,030.0	280,439.7	-6,590.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ	287,030.0	280,439.7	-6,590.3
Дүн	287,030.0	280,439.7	-6,590.3

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл буурсан нь Хөгжлийн банкнаас Буянт-Ухаа-2 хорооллыг санхүүжүүлэх зорилгоор авсан 35.5 сая ам.долларын зээлийг төгрөгт хөрвүүлэн, зээлийн ангиллыг бусад зээлээс урт хугацаат зээлийн ангилалд шилжүүлэн бүртгэсэн, мөн Хөгжлийн банканд хураалгасан дуусаагүй барилгын хэмжээгээр тус банканд төлөх зээлийн өрийг барагдуулсан зэрэгтэй холбоотой байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 491,171.4 сая, эцсийн үлдэгдэл 264,027.8 сая төгрөг болж 227,143.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,581.1	2,470.1	-111.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	66,706.4	8.2	-66,698.2
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	307.6	212.5	-95.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	6,454.8	73,152.9	66,698.1
Хуримтлагдсан үр дүн	414,008.5	187,095.7	-226,912.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,113.0	1,088.4	-24.6
Дүн	491,171.4	264,027.8	-227,143.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	169,528.2	186,876.3	17,348.1
Төсөл	309,676.0	72,706.3	-236,969.7
ТӨҮГ	11,967.3	4,445.3	-7,522.0
Дүн	491,171.4	264,027.8	-227,143.6

Эх сурвалж: БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг Сангийн сайдын багцад шилжүүлсэн тул үүсгэн байгуулагдахад Засгийн газраас оруулсан 111,075.6 сая төгрөгийн хөрөнгийг хаалтын бичилт хийсэнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичилт нь ГЗБГЗЗГ нь дахин үнэлгээтэй үндсэн хөрөнгө акталсан 24.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, гадаад зээлийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг Сангийн сайдын багцад шилжүүлж хаалтын бичилт хийсэн 147,774.9 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оны дуусаагүй барилгаас 2019 онд барьж дууссан төсөл арга хэмжээний 29,586.8 сая, ОССК-аас ТОСК ТӨХХК-д балансаас балансад шилжүүлэн бүртгэхдээ Хэнтий аймгийн ЗДТГ-аас авах авлагыг 1,524.7 сая төгрөгөөр бүртгэсэн боловч 2019.04.22-ны өдөр 156/шш2019/00178 дугаартай шүүхийн тогтоолоор 1,493.0 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 229 дүгээр тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг бууруулсан, өмнөх онуудад хэрэгжүүлсэн техник хяналтын зардлыг буруу тооцсон, техник хяналтын зардлаас зохиогчид өгөх 20 хувийг өглөг үүсгэж бүртгээгүй, зарим зохиогчийн хяналтын зардлыг өглөг үүсгээгүй шууд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн 69.6 сая, нийт 178,924.3 сая төгрөгөөр бууруулан, зөрүү дүнгээр өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуульд заасны дагуу БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант онд 1,850.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 2,494.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 34.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 209 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, хөтөлбөрт зориулан 163,384.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,034.6 сая төгрөгийг урсгал зардалд, 141,350.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 5,000.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн төлбөрт зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсвөөс гүйцэтгэлээр 160,478.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос, урсгал болон хөрөнгийн зардалд 155,478.4 сая төгрөгийг, эргэж төлөгдөх зээлийн төлбөрт 5,000.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 160,478.3 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг үе шатны ажлын гүйцэтгэлээр олгосон, 4 төсөл арга хэмжээ нь батлагдсан зураг төсөвгүй, 3 төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон, 10 төсөл арга хэмжээг бусад шалтгаанаар дутуу гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.5 сая, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслөөс 57.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 343.1 сая, нийт 405.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 243.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 150.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, хөрөнгө оруулалтын зардал, 2 төрийн өмчит аж ахуйн нэгж, 3 зөвлөл болон төсөл хэрэгжүүлэх нэгж, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдэж, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг

бууруулах үндэсний арга хэмжээ төсөл"-ийн санхүүгийн тайланд Севилла Аудит ХХК гэрээгээр аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,868.0 сая төгрөгийн 36 алдаа, зөрчил илрүүлснээс 2,003.9 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 147.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 804.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, 912.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 28 зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан өөрчлөлтийг 144.3 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдлийг 565.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг аудитын явцад залруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 134.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг арилгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын барьцааны үлдэгдэл нийт 134.0 сая төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Тус яамны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд нийт 187 аж ахуйн нэгж байгууллагын 12,938.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 45 аж ахуйн нэгж байгууллагын 804.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, мөн холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 177.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

ГЗБГЗЗГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,192.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,083.8 сая төгрөгийн алдааг залруулж, 108.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

БХБЯ-ны аппаратын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн ба илэрсэн алдаа, зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлсэн.

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, ТОСК ТӨХХК-ийг аудитад хамруулж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 652.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 209.9 сая төгрөгийн алдааг залруулж, 13.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 428.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 10 зөвлөмж өгсөн.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн санхүүгийн тайлангийн аудитаар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 161.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 10 зөвлөмж өгсөн.

Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайланг түүврийн аудитад хамруулсан ба алдаа зөрчил илрээгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ТОСК ТӨХХК-д дамжуулан зээлдүүлэх 2019/194 дугаартай гэрээний дагуу олгосон 5,000.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдлийн асуудлыг дараагийн аудитаар судалж үзнэ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 2419 мэдээллийг хугацаанд нь, 508 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: “Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор ГЗБГЗЗГ-ыг Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх”, 61.1.5-д “Газрын харилцаа, кадастр” гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа учир холбогдох дээд шатны байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 1,115.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 2,398.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, холбогдох баримтын бүрдэл дутуу, шалтгаан тодорхойгүй 22 аж ахуйн нэгж байгууллагын 890.2 сая төгрөгийг барьцаанаас чөлөөлөх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, заавар зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

3.2 Барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 2019 оны 12 дугаар сарын 06-нд батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж бусад зардлыг 48.2 сая төгрөгөөр өсгөж дараа онд шилжүүлэн зарцуулахаар, мөн Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, сургалт зохион байгуулах зардлыг 60.0 сая төгрөгөөр, Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах зардлыг 40.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөн, зарцуулсан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д "Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна", Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журмын 2.4-т "Удирдах зөвлөл нь тайлант жилдээ багтаан Сангийн үйл ажиллагааны тухайн жилийн тайланг хэлэлцэн дүгнэж, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулснаас холбогдох хууль, журам зөрчигдөх,

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, зарцуулах, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журмын 2.4-т заасныг мөрдөж ажиллах,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

3.3 Барилга байгууламжийн норм, нормативын сангийн зарцуулалттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Барилга байгууламжийн норм, нормативын сангаас тайлант онд нэр бүхий 13 хэвлэл, мэдээллийн байгууллагатай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 6-12 сарын хугацаатай байгуулж, гэрээнд гарын үсэг зурсан болон гэрээ байгуулснаас хойш 2-3 хоногт багтаан санхүүжилтийг бүрэн олгохоор заасны дагуу ажил эхлээгүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр 65.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Засгийн газрын 2013 оны батлагдсан "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68 дугаар тогтоолд заасныг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүжилтийг бүрэн олгосноор гэрээний үр дүн, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль, журам зөрчигдөх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээний үр дүнг тооцож, гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулан, ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68 дугаар тогтоолд заасныг мөрдөх,

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	469,109,108.0	482,518,991.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	29,478,633.2	28,065,770.8
33	АВЛАГА	142,264,748.0	152,708,829.8
34	УРЬДЧИЛГАА	13,245,249.4	15,387.5
35	БАРАА МАТЕРИАЛ	31,233,918.2	14,284,064.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	252,886,559.2	287,444,938.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	427,693,059.9	158,917,002.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0
37300	Урт хугацаат зээл	1,000.0	1,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	427,692,059.9	158,916,002.2
39200	Биет хөрөнгө	358,672,238.0	90,414,865.4
39300	Биет бус хөрөнгө	67,935,987.1	67,905,482.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,083,834.8	595,654.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	896,802,167.9	641,435,993.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	405,630,753.1	377,408,176.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	118,600,729.7	96,968,453.0
41300	Өглөг	97,048,313.9	78,295,401.5
41400	Урьдчилж орсон орлого	21,552,415.8	18,673,051.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	287,030,023.4	280,439,723.3
42200	Урт хугацаат зээл	287,030,023.4	280,439,723.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	491,171,414.8	264,027,816.9
51	Засгийн газрын хувь оролцоо	491,171,414.8	264,027,816.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,581,158.8	2,470,083.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	66,706,381.2	8,247.3
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	307,592.9	212,479.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	6,454,792.0	73,152,925.9
51200	Хуримтлагдсан үр дүн	414,008,525.2	187,095,667.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,112,964.7	1,088,413.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	896,802,167.9	641,435,993.2

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	183,663,062.8	191,830,849.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,948,390.7	85,945,594.4
120	Нийтлэг татварын бус орлого	98,948,390.7	85,945,594.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	84,714,672.1	105,885,255.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	143,395,440.2	88,546,091.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,261,634.3	88,546,091.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,991,665.5	36,191,115.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,831,504.4	2,966,745.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,312.0	363,857.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,454.3	220,325.3
2104	Хангамж, бараа материалын зардал	99,730,915.3	274,461.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,029.9	18,949.1
2107	Томилолт, зочны зардал	163,998.1	150,855.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,990,265.3	29,183,832.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,721,186.2	3,012,087.2
211	ХҮҮ	67,707.9	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,269,968.8	52,354,975.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,098.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	40,267,622.6	103,284,758.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	141,649.9	1,874.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,502,815.5	151,299,746.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	34,906,457.0	(48,013,113.8)

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	155,597,331.4	154,123,650.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,298,906.1	47,883,095.3
120	Нийтлэг татварын бус орлого	70,298,906.1	47,883,095.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	85,298,425.2	106,240,555.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,554,184.5	51,585,927.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,554,184.5	51,585,927.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,578,748.8	32,794,515.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,067,497.9	6,243,692.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,559,770.7	1,855,170.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,147.8	190,337.4
2104	Хангамж, бараа материалын зардал	6,297,660.6	11,768,553.0
2105	Нормативт зардал	629.1	632.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,594.1	17,334.2
2107	Томилолт, зочны зардал	295,255.4	177,222.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,143,944.9	5,457,777.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,934,248.2	7,083,796.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,975,435.7	18,791,411.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	112,043,146.9	102,537,723.3
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	384,509.4	662,738.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	85,078,511.6	82,382,096.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,078,511.6	82,382,096.6
2200	Дотоод эх үүсвэрээр	85,078,511.6	82,382,096.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(84,694,002.2)	(81,719,358.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(25,437,532.7)	(22,231,227.4)
14	Бусад эх үүсвэр	4,633,753.4	87,900,121.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	21,422,736.8	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	8,648,549.3	110,131,348.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,911,612.0	(1,412,862.5)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,567,021.3	29,478,633.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,478,633.2	28,065,770.8

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	428,347,872.5	-	428,347,872.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(40,707,822.6)	-	(40,707,822.6)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,640,049.9	-	387,640,049.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,065,121.2	-	1,065,121.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	103,000.0	-	103,000.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	67,456,786.6	-	67,456,786.6
9	Тайлант үеийн үр дүн	34,906,457.0	-	34,906,457.0
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,171,414.7	-	491,171,414.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(179,010,819.5)	-	(179,010,819.5)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,160,595.2	-	312,160,595.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(24,551.4)	-	(24,551.4)
17	Өмчид гарсан өөрчлөлт	(95,113.1)	-	(95,113.1)
19	Тайлант үеийн үр дүн	(48,013,113.8)	-	(48,013,113.8)
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,027,816.9	-	264,027,816.9

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	163,384,727.2	160,478,338.8	2,906,388.4	98.2
III. УРСГАЛ ЗАРДАЛ	17,034,597.5	16,987,369.9	47,227.6	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,034,597.5	16,987,369.9	47,227.6	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,319,844.8	2,319,844.8	0.0	100.0
Үндсэн цалин	1,293,997.9	1,293,997.9	0.0	100.0
Нэмэгдэл	916,112.8	916,112.8	0.0	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	109,734.1	109,734.1	0.0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,980.5	289,980.4	0.1	100.0
Тэтгэврийн даатгал	197,186.8	197,187.0	(0.2)	100.0
Тэтгэмжийн даатгал	23,198.6	23,198.1	0.5	100.0
ҮОМШӨ-ний даатгал	18,558.6	18,558.4	0.2	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,639.6	4,639.6	0.0	100.0
Эрүүл мэндийн даатгал	46,396.9	46,397.3	(0.4)	100.0
Бараа үйлчилгээний урсгал зардал	14,424,772.2	14,377,544.7	47,227.5	99.7
Бичиг хэрэг	37,791.4	37,399.3	392.1	99.0
Тээвэр, шатахуун	27,684.8	31,785.1	(4,100.3)	114.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,846.6	25,632.9	1,213.7	95.5
Дотоод албан томиллолт	62,150.0	62,142.0	8.0	100.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	26,275.7	23,740.2	2,535.5	90.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	832.7	831.9	0.8	99.9
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,727,787.8	1,725,413.9	2,373.9	99.9
Маягт хэвлүүлэх зардал	295,694.4	295,659.4	35.0	100.0
Урсгал засвар	12,449.0	12,443.7	5.3	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	42,161.7	42,107.1	54.6	99.9
Байрны түрээс	70,578.8	70,577.3	1.5	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911.1	1,644.8	266.3	86.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,923,543.6	11,879,440.3	44,103.3	99.6
Бусад урсгал шилжүүлэг	169,064.6	168,726.8	337.8	99.8
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	141,350,129.7	138,490,968.9	2,859,160.8	98.0
Барилга байгууламж	118,213,429.7	117,671,073.4	542,356.3	99.5
Их засвар	22,040,300.0	19,797,397.6	2,242,902.4	89.8
Тоног төхөөрөмж	1,096,400.0	1,022,497.9	73,902.1	93.3
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	5,000,000.0	5,000,000.0	0.0	100.0
Эргэж төлөгдөх зээл	5,000,000.0	5,000,000.0	0.0	100.0
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	163,384,727.2	160,478,338.9	2,906,388.3	98.2
Улсын төсвөөс санхүүжих	163,384,727.2	160,478,338.9	2,906,388.3	98.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,635,728.6		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,635,728.6	-		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	566	590	(24)	104.2
Удирдах ажилтан	13	13	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	112	136	(24)	121.4
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
Гэрээт ажилтан	435	435	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А	Б	В
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		0.0
ОРЛОГЫН ДҮН	-	405,381.3
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	57,856.7
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,470.8
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	343,053.8
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	255,184.2
А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	255,184.2
1. Бараа үйлчилгээний зардал	-	243,282.2
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	27,332.2
Үндсэн цалин	-	25,908.2
Гэрээт ажлын хөлс	-	1,424.0
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	3,401.8
Тэтгэврийн даатгал	-	3,401.8
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	-	212,548.2
Бичиг хэрэг	-	426.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,474.6
Гадаад албан томилолт	-	1,314.0
Дотоод албан томилолт	-	28,467.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	15,200.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,835.0
Газрын төлбөр	-	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	159,830.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,902.0
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,902.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	297.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	150,494.4

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

**2019
он**

Аудитын
нэр:

**Санхүүгийн
тайлангийн аудит**

САГ-2020/22/СТА-ТЭЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

**Барилга, хот байгуулалтын
яам**

сая
төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог, нэр
1. Төсвийн ерөнхийлөн захирагч					
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 134.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	134.0	Акт тогтоосон	Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч	С.Должинсүрэн
2	Тус яамны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд нийт 187 аж ахуйн нэгж байгууллагын 12,938.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 45 аж ахуйн нэгж байгууллагын 804.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	804.1	Албан шаардлага өгсөн	Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч	С.Должинсүрэн
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, холбогдох баримтын бүрдэл дутуу, шалтгаан тодорхойгүй 22 аж ахуйн нэгж байгууллагын 890.2 сая төгрөгийг барьцаанаас чөлөөлөх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй,	-	Зөвлөмж өгсөн	Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч	С.Должинсүрэн
4	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 2019.12.06-нд батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж бусад зардлыг 48.2 сая төгрөгөөр өсгөж дараа онд шилжүүлэн зарцуулахаар, мөн Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, сургалт зохион байгуулах зардлыг 60.0 сая төгрөгөөр, Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах зардлыг 40.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөн, зарцуулсан,	148.2	Зөвлөмж өгсөн	БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
5	Барилга байгууламжийн норм, нормативын сангаас тайлант онд нэр бүхий 13 хэвлэл, мэдээллийн байгууллагатай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 6-12 сарын хугацаатай байгуулж, гэрээнд гарын үсэг зурсан болон гэрээ байгуулснаас хойш 2-3 хоногт багтаан санхүүжилтийг бүрэн олгохоор заасны дагуу ажил эхлээгүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр 65.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.	65.5	Зөвлөмж өгсөн	БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
Дүн		1,151.8			

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.04.25			САГ-2020/22/СТА-ТЕ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд		/сая төгрөгөөр/

Д/д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр						Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан										
А		1	2	3	4	5	6	7	9	10	11	12	13	14	15	16	17	18
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ																		
I. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН																		
1	1	Барилга, хот байгуулалтын сайд			1				4	923.9	2	710.2					2	213.7
		ДҮН			1				4	923.9	2	710.2	1	-	1	-	2	213.7
II. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																		
2	1	ГЗБГЗЗГ			1				4	1,192.0	1	1,083.8					3	108.2
		ДҮН			1				4	1,192.0	1	1,083.8					3	108.2
III. ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																		
3	1	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ			1				5	324.6	1	209.9	1	13.8			3	100.9
4	2	ТОСК ТӨХХК			1				8	327.7					1	-	7	327.7
		ДҮН			2				13	652.3	1	209.9	1	13.8	1	-	10	428.6
IV. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																		
5	1	Барилга, хот байгуулалтын сайд /аппарат/			1				2	-							2	-

6	2	Улсын төсвийн хөрөнгө оруулалт		1				3	938.1			1	134.0	1	804.1	1	-
		ДҮН		1	1			5	938.1			1	134.0	1	804.1	3	-
V. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖ																	
7	1	Дэд бүтцийн шиглалтын өмнөх захиргаа		1													
8	2	Монгол улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл															
		ДҮН		1													
VI. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ																	
9	1	Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл				1		10	161.7							10	161.7
		ДҮН				1		10	161.7							10	161.7
НИЙТ ДҮН				2	4	1		36	3,868.0	4	2,003.9	3	147.8	3	804.1	28	912.2

**Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар
тогтоосон төлбөрийн актын нэгтгэл**

Д/д	№	Харьяа байгууллага	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
А		1	2	3	4	5
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ						
1	1	Барилга хот байгуулалтын сайд	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 134.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	134.0	Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч	С.Должинсүрэн
		ДҮН		134.0		
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
2	1	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн 14 их засварын ажилд зохиогч байхгүй тул 12.0 сая төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэл, 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилгын зураг төслийн баримт бичигт магадлал хийсэн нэр бүхий 12 эксперт нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өөр байгууллагад хянах эрх шилжүүлсэн нийт 1.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тус тус улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	13.8	Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
		ДҮН		13.8		
НИЙТ ТӨЛБӨРИЙН АКТЫН ДҮН				147.8		

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл

Д/д	№	Харьяа байгууллага	Албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
А		1	2	3	4	5
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ						
1	1	Барилга, хот байгуулалтын сайд	Тус яамны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд нийт 187 аж ахуйн нэгж байгууллагын 12,938.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 45 аж ахуйн нэгж байгууллагын 804.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	804.1	Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч	С.Должинсүрэн
		ДҮН		804.1		
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
2	1	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК	1. Ерөнхий удирдлагын зардалд 23,922.7 сая төгрөг зарцуулж, төлөвлөгөөнөөс 5,709.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан, 2. Дотоод хяналтын мэргэжилтэнг үндсэн үүргийн дагуу ажиллуулаагүй. Мөн өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодсон актыг баталгаажуулаагүй, 3. Тайлант онд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдлийг 366.0 сая төгрөгөөр санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	-	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хичээнгүй С.Ерөөлт
		ДҮН		-		
НИЙТ ДҮН				804.1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/38

Улаанбаатар хот

САН 2020/28/СТА-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 4-өөс дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын нийт 134,038,940.00 төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дээрх зөрчлийг арилгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагын барьцааны үлдэгдэл нийт 134.0 сая төгрөгийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Тогтоосон төлбөрийн актыг барагдуулж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч С.Должинсүрэн нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР *[Signature]* О.БАЯРМАА

АКТ
ЗӨВШӨӨРСӨН:
 БХБЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
[Signature] С.МАГНАЙСҮРЭН
 БХБЯ-НЫ САНХҮҮ ХЭЛТСИЙН ДАРГА
 БӨГӨӨД ЕРӨНХИЙ САНХҮҮЧ
[Signature] С.ДОЛЖИНСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 01

№ 01/205

Улаанбаатар хот

САН-2020/02/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд нийт 187 аж ахуйн нэгж байгууллагын 12,938.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 45 аж ахуйн нэгж байгууллагын 804.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын барьцааны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, мөн холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Санхүү хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч С.Должинсүрэн нарт даалгав.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* О.БАЯРМАА

АЛБАН ШААРДЛАГА

ЗӨВШӨӨРСӨН:
БХБЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
[Signature] С.МАГНАЙСҮРЭН
БХБЯ-НЫ САНХҮҮ ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ САНХҮҮЧ
[Signature] С.ДОЛЖИНСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

